



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026 09 22 № УИХ-01/10317

танай _____-ны № _____-т

Улсын Их Хурлын гишүүдийн
асуулт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы 09 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын асуулгын цагаар Ерөнхий сайдад тавих Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т "Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна." гэж заасны дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6. хуудастай.

ДАРГА



С.БЯМБАЦОГТ

2026000227

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 09
дугаар сарын 22-ны өдрийн 2026/09/22/09/22
дугаар албан бичгийн хавсралт

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы
09 дүгээр сарын 25-ны өдрийн Баасан гарагийн нэгдсэн хуралдааны
Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайдаас асуухаар ирүүлсэн
Улсын Их Хурлын гишүүдийн асуулт**

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	Сэдэв: Төрөө хямралаас гаргасан уу? Түмнээ ядуурлаас аварсан уу?
2	Ж.Баярмаа	1. Засгийн газар байгуулагдсанаас хойш Монгол Улсын ядуурлын түвшин хэдэн нэгж хувиар буурч, хэдэн иргэн ядуурлаас гарсан, мөн өрхийн бодит орлого, бодит хэрэглээ, худалдан авах чадвар ямар хэмжээгээр өөрчлөгдсөн гэж тооцож байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтэд үндэслэн Засгийн газрын ядуурлыг бууруулах бодлого бодит үр дүнд хүрсэн гэж дүгнэж байгаа эсэхэд тодорхой тоон мэдээллээр хариулна уу.
3	Ж.Баясгалан	1. Ард түмнээ ядуурлаас аврахын тулд Таны хийж байгаа гурван гол алхам; 2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах болсон хамгийн том шалтгаан.
4	Ц.Баатархүү	Сэдэв: Төрөө хямралаас гаргасан уу? Түмнээ ядуурлаас аварсан уу? Ядуурлын түвшин 27.1 хувьтай байна. Макро эдийн засгийн өсөлтийг яг хэзээ, ямар бодитой механизмаар өрх бүрийн хаалгаар оруулж, иргэдийн бодит худалдан авах чадварыг дээшлүүлэн ядуурлыг статистикийн төдий бус, амьдрал дээр бууруулах вэ?
5	С.Ганбаатар	1. Олон улсын нөхцөл байдлын улмаас бензин шатахууны хомсдол ард иргэд, аж ахуй нэгжүүдэд хүнд туслаа. Засгийн газар үүний эсрэг авсан арга хэмжээ үр дүнгийн талаар:
6	Б.Жаргалан	Танай намын "түмнээ ядуурлаас аварна" гэсэн амлалт биелсэн гэж Та үзэж байна уу? Уул уурхайн экспорт, төсвийн орлого, эдийн засгийн хэмжээ олон дахин өссөн атлаа яагаад ядуурал дөрвөн хүн тутмын нэгийг хамарсан хэвээр байна вэ? Өсөлтийн үр өгөөжийг иргэдэд хүргэж чадаагүйн хариуцлагыг хэн хүлээх вэ?
7	Ц.Мөнхтуяа	1. Боловсролын салбарын санхүүжилт, багшийн цалин хөлс, хүний нөөцийн хомсдол, сургалтын чанар, тэгш

		хүртээмжийн асуудал өнөөдөр ямар түвшинд байгааг бодит үзүүлэлтээр дүгнэх шаардлагатай байна. Таны тэргүүлсэн Засгийн газар боловсролын салбарыг хямралаас гаргах, багш нарын цалин хөлсийг амьжиргааны өртөгт нийцүүлэн нэмэгдүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах чиглэлээр ямар бодит үр дүнд хүрсэн бэ? 2. Боловсролын санхүүжилт, багшийн бодит цалин, багшийн хомсдол, сургалтын чанарын өмнөх болох өнөөгийн үзүүлэлтийг харьцуулан тайлбарлаж, багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас доошгүй түвшинд хүргэх зорилтыг хэзээ, ямар санхүүжилтээр бүрэн хэрэгжүүлэхээ тодорхой хариулна уу?
8	С.Одонтуяа	Сэдэв: Төрөө хямралаас гаргасан уу? Түмнээ ядуурлаас аварсан уу? Монгол гэр бүлийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд ямар ажлууд хийсэн бэ? Төрөлт яагаад эрс буурав? Иргэд гадаад улс руу яагаад олноор явах болов? Эх орондоо амьдрах нөхцөлгүй болж байгаа юм биш үү? Дээгүүрээ нийлж зөвхөн хулгай л хийдэг гэж бодсоноор гадаадад гарч амьдаръя гэсэн бодол давамгайлсан юм биш үү?
9	С.Цэнгүүн	- Инфляцыг ямар хүчин зүйл, шалгуураар тооцож байгаа вэ? 2026 оны төсөвт инфляцыг жилийн дунджаар 7 хувь гэж тооцсон. Гэтэл долоодугаар сард инфляц 13 хувьд хүрсэн. Анхны 7 хувийн төсөөлөлдөө хүрэх боломж одоо хэвээр үү? - Төсвийн тодотгол энэ хэвээр батлагдвал инфляцад ямар нөлөө үзүүлэх вэ? Монгол банкнаас инфляц 0.7 хувь, бусад эдийн засгийн шинжилгээний байгууллага, судлаачдын зүгээс үүнээс ч өндөр хувиар өсөхөөр байгааг анхааруулсаар байна. Та үүнтэй санал нийлэх үү? Инфляц 2026 оны 12 дугаар сард хэдэн хувьтай байх вэ? Энэ нь найдвартай, оновчтой тооцоолол байж чадах уу? Инфляц таны энэ тооцоолсноос өндөр байвал хэнд ямар хариуцлага хүлээлгэх вэ? Та хариуцлага хүлээж чадах уу? 2026 оны төсвийн тодотголоор 11 дүгээр сараас 435.0 мянган ахмад настанд дунджаар 220 мянган төгрөгийн суурь тэтгэвэр олгоход 196.3 тэрбум төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн өсөлтийг 50 хувьд хүргэхэд 166.3 тэрбум төгрөг тусгаж байгаа нь өрхийн хэрэглээ болон нийт эрэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Уг нөлөөллийг бууруулах чиглэлээр ямар арга хэмжээг, ямар хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?

		Энэхүү арга хэмжээнд зориулан хэдий хэмжээний төсөв зарцуулахаар төлөвлөсөн бэ? Арга хэмжээ тус бүр инфляцыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ? Хүлээгдэж буй үр дүнг ямар тооцоо, судалгаанд үндэслэсэн бэ? - Эрчим хүчний салбарт өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл хэдэн хувьтай байна вэ? Одоо ямар ажлууд хийгдэх хүлээгдэж байна вэ? Эдгээр ажил хэдэн сарын хэдэн гэхэд дуусах вэ? Энэ өвөл цахилгаан хязгаарлах уу? Цахилгаан хязгаарласан тохиолдолд яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бэлэн үү? Ямар нөөц нэмэлт ашиглах вэ?
10	С.Эрдэнэболд	1. Төрөө хямралаас гаргасан гэж та хэлж байна. Тэгвэл яг юугаараа гаргасан бэ? 2. Улсын өр, төсвийн алдагдал, инфляц, төгрөгийн худалдан авах чадвар, иргэдийн бодит орлого зэрэг гол үзүүлэлтээр Засгийн газар ажил авсан үеийн нөхцөлтэй өнөөдрийн байдлыг тоогоор, баримтаар харьцуулж хэлнэ үү. 3. Зүгээр л “эдийн засаг өссөн” гэж ярих биш, төрийн санхүү сайжирч, иргэдийн амьдралд бодитоор ямар өөрчлөлт гарсан бэ? 4. Хэрэв төр хямралаас гарсан юм бол иргэдийн амьдрал яагаад хямралаас гарсан мэт мэдрэгдэхгүй байна вэ? 5. Түмнээ ядуурлаас аварсан гэж та хэлж чадах уу? 6. Өргөн хэрэглээний барааны үнэ өсөж, өрхийн зардал нэмэгдэж, иргэдийн бодит орлого амьдралын өртгөө гүйцэхгүй байгаа нөхцөлд “ард иргэдийг ядуурлаас аварсан” гэж ямар бодит үзүүлэлтэд үндэслэн хэлж байгаа вэ? 7. Засгийн газар ажил авсан үеэс өнөөдрийг хүртэл ядуурлын түвшин хэдэн хувиар буурсан, хэдэн өрх ядуурлаас гарсан, иргэдийн бодит орлого хэдэн хувиар өссөн бэ? 8. Хэрэв эдгээр үзүүлэлтээр тодорхой ахиц гарсан бол тоог нь хэлнэ үү. Харин хэлэх тоо байхгүй бол “түмнээ ядуурлаас аварсан” гэдэг дүгнэлтээ юунд үндэслэж байна вэ?
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ		
11	М.Ганхүлэг	Хууль тогтоомжийн биелэлт: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг үнэлж, залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал болон бодлого,

		зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа чиглэлүүдийг тодорхойлсны үр дүнд Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 10 дугаар тогтоол гарч, Засгийн газарт тодорхой чиглэлээр үүрэг өгсөн. Уг тогтоол гарснаас хойш жил гаруйн хугацаа өнгөрсөн тул дараах асуултыг Засгийн газраас асууя. 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын үр дүн, үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг, залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилго, зорилтыг тусгасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан. Энэ заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2. Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, хүмүүжил, ёс суртахуун гэсэн дараах 5 үйл ажиллагааг шаардлагатай санхүүжилтийн хамт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ заалтын хэрэгжилт ямар байна вэ? Үүний хүрээнд: 2.1. Оюутан, залуучуудыг дэмжих нөхцөл бололцоог бүрдүүлэх хүрээнд оюутны шилдэг их сургуулиудын зэрэглэлээр тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургуулиас багш, судлаач-багш нарыг урьж ажиллуулах, тус сургуулийн салбарыг Монгол Улсад нээх боломжийг судлах, залуучуудын дэд бүтэц, оролцоог сайжруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй боловсрол олгох арга хэмжээний хэрэгжилт ямар байна вэ? 2.2. Гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудыг эх орондоо ирж ажиллаж, амьдрахад дотоодын залуучууд хөдөө, орон нутагт өндөр цалинтай ажиллах үйлчилгээний судалгааг хийж, судалгааны үр дүнд тулгуурлан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.3. Залуу малчдыг дэмжих хүрээнд уламжлалт нүүдлийн мал аж ахуйн салбарыг үр ашигтай, өгөөжтэй өсгөн нөлөөлөх, хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даган зохицох
--	--	---

		чиглэлээр тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, залуу малчдын гэр бүл төлөвлөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэхийг дэмжих заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.4. Орон нутгийн залуучуудыг тухайн аймаг, сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангах хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлд, сум бүрд жилд 10-аас дээш өрхийн түрээсийн болон хувийн орон сууцад хамруулах боломжийг судалж, холбогдох тооцооллыг танилцуулах заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.5. Хөдөө хязгаар нутагт амьдарч буй залуучуудад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.6. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмыг шинэчлэх, оюутны цагийн хөдөлмөрийн цалин хөлснөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг уян хатан тогтоох заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.7. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн залуучуудын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч буй залуучуудад зориулан, Залуучуудын хөгжлийг дэмжих сан байгуулах талаар судалж, танилцуулах заалтын хэрэгжилт ямар байна вэ? 2.8. Өсвөр үе, залуучуудад хүмүүжил, ёс суртахууны төлөвшүүлэх хүрээнд тэдний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн үйл ажиллагааг засаг захиргааны нэгжийн Засаг дарга бүр тэгш хамралтын зарчим дээр үндэслэн хэрэгжүүлэх заалтын хэрэгжилт ямар байна вэ?
12	Д.Энхтүвшин	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: 1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар хавсралтаар тус хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг баталсан. Тус хавсралтын 13 дахь хэсэгт Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг жил бүр 1 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан. 2025 оны гүйцэтгэл зорилтод түвшиндээ хүрээгүй байна. Дээрх шалгуур үзүүлэлтийн 2026 оны хүлээгдэж буй үр дүн болон цаашид эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах чиглэлд ямар арга хэмжээ авах, төсвийн бодлоготой хэрхэн уялдуулж хэрэгжүүлэх вэ?

		2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3.2-д “Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд гурван талт болон олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ” гэж тусгасан. Өнгөрсөн хугацаанд хувийн хэвшил, төсөв, цалин, нийгмийн даатгалтай холбогдох олон хууль баталсан. Хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагын оролцоо, төлөөлөх чадамж сул байсан. Түүнчлэн, энэ онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхдээ хувийн хэвшлийн оролцоог хангаагүй, санал, дүгнэлтийг хэлэлцэлгүй шийдвэрлэсэн. Цаашид хууль тогтоох, төсөв, хөгжлийн бодлого зэрэг баримт бичгийг батлахдаа Иргэд, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагын оролцоог сайжруулах, ил тод нээлтэй хэлэлцэж, санал дүгнэлтийг тусгах талаар ямар арга хэмжээ авах вэ?
ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ		
13	Б.Батбаатар	1. Та өөрөө авлигын төсөөллийн индекс 10 байраар ухарсныг хүлээн зөвшөөрсөн. Дараагийн үнэлгээгээр хэдэн байр ахихыг зорьж байна вэ? Тоо хэлнэ үү. 2. Энэ оны зургаадугаар сард иргэд зэсийн экспортыг зогсоож, уул уурхайн орлогын дотоодын эзлэх хувийг нэмэхийг шаардсан. Тэр шаардлагад Засгийн газар ямар тоогоор хариулсан бэ? Өнөөдөр нэг тонн зэсээс иргэнд хэдэн төгрөг очиж байна вэ? 3. Та Төрийн албаны нууцын тухай хуулиар 814 нууцыг ил болгоно гэлээ. Он, сар, өдрөө хэлнэ үү-хэзээ ил болох вэ?